



СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ

ХИШИГ УУЛ ХК

Хувьцаат компани

2024 оны 12-р сарын 31-ний өдрөөр

дуусгавар болсон жилийн

санхүүгийн тайлан

Улаанбаатар хот, 2025 он

ХИШИГ УУЛ ХК

(Монгол улсад бүртгэлтэй компани)

Аудитлагдсан санхүүгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

АГУУЛГА	ХУУДАС
КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ	4
ЗАХИРАЛ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ	5
ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	6-7
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	8
ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН	9
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	10
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	11
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД	12-27

КОМПАНИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

: Я.Нэргүй

АЛБАН ЁСНЫ ХАЯГ

: Улаанбаатар хот, Багануур, 1-р хороо,
Нацагдоржийн гудамж, Хэрлэн худалдааны төв

ХАРИЛЦАГЧ БАНК

: Голомт банк, Хаан банк, Төрийн банк

Аудиторууд

: СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК

Мэргэшсэн нягтлан бодогчид

ЗАХИРЛУУД БА ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

ХИШИГ УУЛ ХК (цаашид компани гэнэ)-ийн гүйцэтгэх захирал Я.Нэргүй, би энэхүү хавсралтад үзүүлсэн санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл, мөнгөн гүйлгээг санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг батламжилж байна.



УЛААНБААТАР ХОТ

ХИШИГ-УУЛ
ХК

Я.Нэргүй

Улаанбаатар хот, монгол улс

Огноо:



“СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ” ХХК

БАТАЛГААХУЙ ТЭГЭ АУДИТ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ЗӨВЛӨХ АЖИЛЧЛЭГ, ЗӨВЛӨГӨӨ

Баянзүрх дүүрэг, 3-р хороо, Оршил төв 501 тоот
Улаанбаатар хот, Монгол улс, 16010, Утас: 11-976-99046494

Огноо: 2025-04-15

№ 25/50

Улаанбаатар хот

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ХИШИГ УУЛ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

Дүгнэлт

Бид 2024 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн ХИШИГ УУЛ ХК компанийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар ХИШИГ УУЛ ХК компанийн 2024 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдал, тухайн жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв толилуулж (эсвэл эдгээрийн талаар үнэн бөгөөд зөв ойлгоц өгч) байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд хүлээх Үүрэг Хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл үүнээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа

зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн Аудитад хүлээх Аудиторын хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт гаргах нь бидний хариуцлага юм. Бид аудитаа Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Тэдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагад нийцэж ажиллах мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохимжтой баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Сонгон авах горимууд нь залилан болон алдааны улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдсэнээс үүсэх эрсдэлийн үнэлгээ зэргийг багтаасан аудиторуудын мэргэжлийн үнэлэмжээс хамаарна. Тэдгээр эрсдэлийн үнэлгээнүүдийг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй эсэх талаар дүгнэлт гаргах зорилгоор биш зөвхөн тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиох үүднээс байгууллагын санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, тэдгээрийг үнэн зөв толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг харгалзаж үздэг.

Мөн аудитын ажилд хэрэгжүүлж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын таарамж, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцооллуудын бодитой эсэхийг үнэлж үзэх ажил орно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалсан аудиттай холбогдуулан Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулж гаргасан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК

Мэргэшсэн нягтлан бодогч

Гүйцэтгэх захирал



Ч.ЭНХЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот
Баянзүрх дүүрэг, 3-р хороо, Оршил төв 501 тоот

Утас: 976 – 9904 6494; 86030388

ХИШИГ УУЛ ХК

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

2024 ОНЫ 12 САРЫН 31	Тэмдэглэл	23.12.31	24.12.31
ХӨРӨНГӨ			
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ			
Мөнгөн хөрөнгө	4	20,760,167.34	22,207,334.58
Бусад авлага	5	14,044,439.17	14,044,439.17
Бараа материал	6	377,970,528.78	348,871,299.93
Эргэлтийн хөрөнгийн дүн		<u>412,775,135.29</u>	<u>385,123,073.68</u>
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ			
Үндсэн хөрөнгө	7	577,010,830.63	548,985,357.26
Биет бус хөрөнгө	8	400,000.00	400,000.00
Урт хугацаат хөрөнгө оруулалт	9	459,625,625.25	459,625,625.25
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		<u>1,037,036,455.88</u>	<u>1,009,010,982.51</u>
Нийт хөрөнгө		<u>1,449,811,591.17</u>	<u>1,394,134,056.19</u>
ӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
ӨР ТӨЛБӨР			
Дансны өглөг	10	699,145,964.47	586,331,158.72
Татварын өр	11	41,626,696.09	29,210,850.29
НДШ-н өглөг		-	162,530.04
Урт хугацаат зээл	12	32,097,388.91	32,097,388.91
Өр төлбөрийн дүн		<u>772,870,049.47</u>	<u>647,801,927.96</u>
ЭЗДИЙН ӨМЧ			
Төрийн өмч	13	29,520,500.00	29,520,500.00
Хувийн өмч		57,304,500.00	57,304,500.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		658,460,091.00	658,460,091.00
Эздийн өмчийн бусад хэсэг		83,645,405.00	83,645,405.00
Хуримтлагдсан ашиг		(151,988,954.30)	(82,598,367.77)
Эздийн өмчийн дүн		<u>676,941,541.70</u>	<u>746,332,128.23</u>
Нийт эздийн өмч ба өр төлбөр		<u>1,449,811,591.17</u>	<u>1,394,134,056.19</u>

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Хувийн өмч	Төрийн өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт
2023 оны 12 сарын 31 үлдэгдэл	57,304,500.00	29,520,500.00	658,460,091.00	83,645,405.00	(151,988,954.30)	676,941,541.70
Залруулсан үлдэгдэл	57,304,500.00	29,520,500.00	658,460,091.00	83,645,405.00	(151,988,954.30)	676,941,541.70
Тайлант үеийн ашиг, алдагдал	-	-	-	-	69,390,586.53	69,390,586.53
2024 оны 12 сарын 31 үлдэгдэл	57,304,500.00	29,520,500.00	658,460,091.00	83,645,405.00	(82,598,367.77)	746,332,128.23

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

ХИШИГ УУЛ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	23.12.31	24.12.31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн	1,761,343,994.29	1,658,596,037.50
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,704,194,276.95	1,658,596,037.50
Бусад мөнгөн орлого	57,149,717.34	-
Мөнгөн зарлагын дүн	1,613,179,087.13	1,657,148,870.26
Ажилчдад төлсөн	68,602,852.57	106,484,034.0
Нийгмийн даатгалын шимтгэлд төлсөн	17,757,413.49	22,591,509.96
Бараа материал худалдан авахад төлсөн	1,274,688,110.08	1,356,347,614.2
Ашиглалтын зардалд төлсөн	79,074,386.83	89,906,997.3
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	16,768,687.07	11,046,634.0
Хүүний төлбөрт төлсөн	3,026,179.17	-
Татварын байгууллагад төлсөн	48,137,279.69	-
Даатгалын төлбөрт төлсөн	-	70,772,080.85
Бусад мөнгөн зарлага	105,124,178.23	-
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн дүн	148,164,907.16	1,447,167.24
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн зарлагын дүн	1,879,000.00	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,879,000.00	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн дүн	(1,879,000.00)	-
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн зарлагын дүн	125,927,236.83	-
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	125,927,236.83	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(125,927,236.83)	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	20,358,670.33	1,447,167.24
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	401,497.01	20,760,167.34
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	20,760,167.34	22,207,334.58

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

ХИШИГ УУЛ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

1. КОМПАНИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ БА ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦ

Компанийн талаарх мэдээлэл

Компани нь үйл ажиллагаагаа дараах чиглэлээр явуулна.

- Хүнсний дэлгүүрийн үйлчилгээ
- Зоогийн газар, баарны үйлчилгээ
- Ажлын байрны түрээслэл

Тухайн тайлант хугацаанд үндсэн үйл ажиллагаанд ямар нэгэн өөрчлөлт гараагүй болно.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД

2.1 ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ

Санхүүгийн тайлангуудыг түүхэн өртгийн зарчмаар бэлтгэсэн болно. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг Монгол төгрөгөөр тайлагнасан.

НИЙЦЛИЙН МЭДЭГДЭЛ

Компанийн санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс баталж гаргасан Санхүүгийн тайлагналын Олон Улсын Стандартууд (СТОУС)-ын дагуу бэлтгэгдсэн болно.

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГОД ОРОХ ӨӨРЧЛӨЛТҮҮД

НББОУС, СТОУС ба Санхүүгийн тайлагналын Олон улсын тайлбарын хороо (СТОУТХ)-ноос гаргасан тайлбаруудыг тайлант хугацаанд дагаж мөрдсөн ба дараах шинэ болон нэмэлт өөрчлөлтүүдийг хүчин төгөлдөр үйлчилж эхлэх өдрөөс нь хэрэглэнэ гэсэн чиглэлтэй. Үүнд:

Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс гаргасан 2024 оны 1 сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн СТОУС-ын өөрчлөлтүүдийг тайлант жилд хэрэгжүүлсэн.

- СТОУС 17 Даатгалын гэрээ
- НББОУС 1-д орсон нэмэлт өөрчлөлтүүд Эргэлтийн ба эргэлтийн бус өр төлбөрийн ангилал
- НББОУС 1 болон СТОУС Практик тайлагнал 2-д орсон нэмэлт өөрчлөлтүүд Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогыг тодруулах нь
- НББОУС 12 Нэг удаагийн гүйлгээнээс үүссэн хойшлогдсон татвар
- НББОУС 8 Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын тодорхойлолт

Дээрх өөрчлөлтүүд нь Компанийн санхүүгийн байдлын тайлан, дэлгэрэнгүй орлогын тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгад материаллаг нөлөө үзүүлээгүй болно.

2024 оны 1 сарын 1-нээс эхлэн Компанийн санхүүгийн тайлангуудыг батлан гаргах үед батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд болон тайлбаруудыг доор тодруулсан болно. Эдгээр

ХИШИГ УУЛ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

- Компани гүйцэтгэлийн үүргээ биелүүлсэн цаг хугацаатай зэрэгцэн, уг ажлын гүйцэтгэлээр дамжуулан худалдан авагч үр өгөөж хүртэх;
- Компанийн гүйцэтгэлийн үүргийн биелэлт нь ямар нэг хөрөнгийг бий болгодог эсвэл хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлдэг бөгөөд уг хөрөнгө бий болсон эсвэл үнэ цэнэ нь нэмэгдэх бүрт худалдан авагч хяналтыг өөртөө авах;
- Компанийн гүйцэтгэлийн үүргийн биелэлтээр дамжин бий болж буй хөрөнгийг Компани ашиглаж үр өгөөж хүртэх боломжгүй хэдий ч гүйцэтгэлийн үүрэг хангагдах бүрт төлбөр хүлээн авах эрхтэй байх.

Бусад тохиолдолд, худалдан авагч нь өөр хоорондоо ялгаатай бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээний хяналтыг авах үед тодорхой нэг хугацаанд хангагдах гүйцэтгэлийн үүрэг гэж үзэж орлогыг хүлээн зөвшөөрнө.

Хүүний орлого

Үр ашиг хүүний аргаар аккрузлдах үед хүүний орлогыг хүлээн зөвшөөрнө.

(в) Үйл ажиллагааны зардал

Үйл ажиллагааны зардал нь тайлант хугацааны үед өөрийн хөрөнгийн бууралт (хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг олгохоос бусад бууралт)-ыг үүсгэж буй эдийн засгийн үр ашгийн гадагшлах урсгал, хөрөнгийн бууралт өр төлбөрийн нэмэгдлээс үүснэ. Ерөнхий болон удирдлагын зардал бусад зардал санхүүгийн зардлыг гаргасан үед нь дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

(г) Орлогын албан татвар

(i) Өнөөгийн орлогын албан татвар

Одоогийн болон өмнөх тайлант хугацааны өнөөгийн албан татварыг хөрөнгө ба өр төлбөрийг татварын байгууллагад төлөх дүнгээр хэмжинэ. Энэ дүнг тооцоолоход хэрэглэсэн татварын хувь хэмжээ, татварын хуулиуд нь тайлант хугацааны эцсийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан.

(ii) Хойшлуулсан орлогын албан татвар

Хойшлуулсан орлогын албан татварыг тайлагналын өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татварыг суурь, тэдгээрийн санхүүгийн бүртгэлийн дүн 2-ын хооронд түр зөрүүний дүнгээс тайлан тэнцлийн өр төлбөрийн аргыг хэрэглэн тооцдог.

Дараахаас бусад бүх түр зөрүүнүүд дээр хойшлуулсан орлогыг албан татварын өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Хэрэв хойшлуулсан орлогын албан татварын өр төлбөр нь гүүдвилээс эсвэл бизнесийн нэгдлийн үеийн бус гүйлгээнээс үүссэн ба гүйлгээ хийх үед нягтлан бодох бүртгэлийн ашиг

ХИШИГ УУЛ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

ба татвар ногдох ашгийн аль алинд нөлөө үзүүлэхгүй хөрөнгө, өр төлбөрүүдийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн бол

- Охин болон хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт, хамтарсан компани дахь ашиг сонирхолтой холбоотой татвар ногдох түр зөрүүнүүдийн хувьд, үүссэн түр зөрүү арилах хугацааг толгой компани, хөрөнгө оруулагч хянаж байдаг ба түр зөрүү нь ойрын ирээдүйд арилахгүй байх магадлалтай байгаа бол

Охин болон хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт, хамтарсан компани дахь ашиг сонирхолтой холбоотой татвар ногдох түр зөрүүнүүдийн хувьд, үүссэн түр зөрүү нь ойрын ирээдүйд арилах ба түр зөрүүг ашиглаж болох татвар ногдох ашиг олох магадлал байгаа бол Хойшлуулсан орлогын албан татварын бүртгэлийн дүнг тайлант хугацаа бүрт хянаж үздэг ба энэхүү хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн ашиглахад хангалттай хэмжээний татвар ногдох орлого орж ирэх магадлал буурах үед уг бүртгэлийн дүнг бууруулна. Үл хүлээн зөвшөөрсөн хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийг тайлант хугацаа бүрт дахин үнэлж үздэг ба хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийг ашиглахыг зөвшөөрсөн татвар ногдох орлого ирээдүйд орж ирэх магадлалтай болсон үед хүлээн зөвшөөрнө.

Хөрөнгийн олж авах эсвэл өр төлбөрийг барагдуулах тэр тайлант хугацаанд хэрэглэгдэнэ гэж хүлээж байгаа (тайлант жилийн эцсийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан татварын хувь хэмжээ, татварын хуулиуд дээр үндэслэн) татварын хувь хэмжээгээр хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө, өр төлбөрийг хэмжинэ.

(д) Ажиллагсдын тэтгэмж

i. Богино хугацаат тэтгэмж

Цалин ба түүнтэй холбогдох бусад зардлуудыг Компанийн ажиллагсдын холбогдох үйлчилгээг үзүүлсэн тухайн жилд нь зардалд тусгана.

Ажилтнуудад ээлжийн амралт зэрэг богино хугацааны чөлөөтэй үед нөхөн олговрыг ажилласан жилийг нь харгалзан олгодог бөгөөд өвчтэй байх хугацааны нөхөн олговрыг цаг тухайд нь олгодог байна.

ii. Заавал төлөх даатгалын шимтгэлүүд

Монгол улсын холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нь Монгол Улсын Эрүүл Мэнд, Нийгмийн даатгалын санд шимтгэл төлдөг. Эдгээр шимтгэлийг гарсан хугацаанд нь дэлгэрэнгүй орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

(е) Үндсэн хөрөнгө

Бүх үндсэн хөрөнгийг өртгөөр нь анх бүртгэдэг. Дараагийн тайлант хугацаанд гарсан зардлыг тухайн зардалтай холбогдсон ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг Компани хүртэх магадлалтай ба өртгийг нь найдвартайгаар хэмжих боломжтой тохиолдолд л хөрөнгийн бүртгэлийн дүнд нэмж эсвэл тусдаа хөрөнгө болгох хоёрын аль таарамжтай гэж үзсэнээр нь хүлээн зөвшөөрдөг. Аливаа

ХИШИГ УУЛ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Сольсон хэсгийн бүртгэлийн дүнг үл хүлээн зөвшөөрнө. Бүх урсгал засварыг тэдгээрийн гарсан тайлангийн хугацаанд дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

Хүлээн зөвшөөрсний дараах үед үндсэн хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан өртгөөр илэрхийлдэг.

Хөрөнгийг ашиглалтаас хасах эсвэл борлуулах үед тухайн хөрөнгийн үлдэгдэл ба хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн аливаа бууралтыг данснаас хасаж, холбогдох аливаа олз эсвэл гарзыг тайлант хугацааны орлогын тайланд бүртгэнэ.

Хөрөнгө тус бүрийн өртгийг үлдэх өртөг хүртэл нь ойролцоолон тооцоолсон дараах ашиглалтын хугацааг ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар элэгдүүлнэ.

Компьютер	2 жил
Тавилга, тоног төхөөрөмж	10 жил
Машин механизм	10 жил

Үндсэн хөрөнгийн дүн, элэгдүүлэх хугацаа, арга нь өмнө хийгдсэн тооцоолол ба үндсэн хөрөнгөнд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн өгөөжийн хүлээгдэж буй хэрэглээний хэв загварт нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах үүднээс үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жилийн эцэс бүрт хянаж үздэг.

Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах үед эсвэл түүний ашиглалт, борлуулалтаас ирээдүйд эдийн засгийн үр ашиг хүлээгдэхээргүй болсон үед үл хүлээн зөвшөөрнө. Үндсэн хөрөнгийн борлуулалтын цэвэр орлого (хэрэв байгаа бол), дансны цэвэр үнэ хоёрын зөрүүг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

Үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жил бүр хянаж, шаардлагатай бол залруулга хийнэ.

(ё) Бараа материал

Бараа материалыг анх өртгөөр нь бүртгэдэг. Дараа нь бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар тайлагнадаг. Бараа материалын өртгийг сарын жигнэсэн дундаж өртгийн аргаар тооцоолдог. Цэвэр боломжит үнэ цэнэ гэдэг нь хэвийн бизнесийн нөхцөлд бараа материалын тооцоолсон худалдан борлуулах үнээс түүнийг үйлдвэрлэх болон худалдан борлуулахад нэмж гарахаар тооцсон зардлыг хассан дүн юм.

Бараа материалын цэвэр боломжит үнэ цэнэ нь өртгөөсөө доогуур байвал, Компани бараа материалын үнийн бууралтын хасагдуулга байгуулах ба ашиг алдагдалд зардлаар бүртгэдэг. Цэвэр боломжит үнэ цэнийн өсөлтөөс үүссэн бараа материалын хасагдуулгын буцаалтыг, буцаалт гарсан тайлант хугацаанд нь ашиг алдагдалд зардлын бууралтаар хүлээн зөвшөөрнө.

Бараа материал зарагдсан үед, тайлант хугацаанд холбоотой орлогыг хүлээн зөвшөөрөх ба бараа материалын өртгийн дүнг зардлаар хүлээн зөвшөөрнө.

ХИШИГ УУЛ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

(ж) Санхүүгийн хэрэглүүр

Компани тухайн хэрэгслийн гэрээний нэг оролцогч тал болсон үед санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өрийг санхүүгийн байдлын тайланд тусгадаг.

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг анх үүсэх үеийн бодит үнэ цэнээр бүртгэнэ. Санхүүгийн хэрэгсэл (бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг санхүүгийн хөрөнгө ба өрийн хэрэгслээс бусад)-ийг гаргах эсвэл худалдан авахтай шууд холбоотой гарсан зардлыг анх бүртгэлд тусгахдаа санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ дээр нэмж эсвэл ба өр төлбөрийн бодит үнэ цэнээс хасч бүртгэнэ. Бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг санхүүгийн хөрөнгө ба өрийн хэрэгслийг гаргах эсвэл худалдан авахтай шууд холбоотой гарсан зардлыг шууд тухайн жилийн ашиг алдагдлаар бүртгэнэ.

i. Анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт ба ангилал

Дараах нөхцлүүдийг хангасан өрийн хэрэгслүүд нь дараа үеүдэд хорогдуулсан өртгөөр хэмжигдэнэ:

- Мөнгөн урсгалыг цуглуулахын тулд санхүүгийн хөрөнгийг эзэмших зорилготой бизнесийн загвараар эзэмшдэг;
- Зөвхөн үндсэн төлбөрийн төлөлт ба гэрээний нөхцлөөр тодорхой заасан өдрөөрх төлөгдөөгүй үндсэн төлбөрийг үлдэгдэлд тооцсон хүүгийн төлбөрөөс бүрдэх төлбөрүүдийн мөнгөн урсгалыг тогтоосон хугацаанд хуваарийн дагуу хүлээн авах нөхцөлтэй байх.

Дараах нөхцлүүдийг хангасан өрийн хэрэгслүүдийг хэмжихдээ бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь тухайн жилийн бусад дэлгэрэнгүй орлогоор тусгана (БҮЦӨБДО):

- Мөнгөн урсгалыг цуглуулахын тулд эсвэл арилжаалах зорилгоор санхүүгийн хөрөнгийг эзэмших зорилго бүхий бизнесийн загвараар эзэмшдэг;
- Тодорхойлон заасан өдрүүдэд зөвхөн төлөгдөөгүй үлдсэн үндсэн төлбөр ба хүү төлөлтийн мөнгөн урсгалыг хүлээн авах санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцөлтэй байх.

Бусад санхүүгийн хөрөнгийг хэмжихдээ бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг (БҮЦАА).

Дээр дурдсанаас үл хамааран, Компани санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед дараах ангиллыг сонгон бүртгэж болно:

- Компани тодорхой шалгууруудыг хангасан тохиолдолд буцаах сонголтгүйгээр өмчийн хэрэглүүр дэх хөрөнгө оруулалтыг дараа үеүдэд хэмжихдээ бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогоор тусгана.
- Компани өрийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалтыг хорогдуулсан өртөг эсвэл бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэх зарчмыг сонгосон байсан боловч бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тайлагнах нь илүү тохиромжтой, бүртгэлийн нийцгүй байдлыг арилгана гэж үзэж байвал бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тухайн жилийн ашиг алдагдлыг тусгаж болно.

Компанийн санхүүгийн хөрөнгө нь хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгөөс бүрдэж байна.

ХИШИГ УУЛ ХК САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Анхлан хүлээн зөвшөөрөлтийн үед санхүүгийн хөрөнгийн ангилал нь тухайн гэрээний мөнгөн гүйлгээний шинж чанар ба Компанийн хөрөнгийг удирдах бизнесийн загвараас хамаарна. Компани нь санхүүгийн томоохон бүрэлдэхүүн хэсэггүй борлуулалтын авлагаас бусад санхүүгийн хөрөнгийг анхлан бодит үнэ цэнээр нь хэмжиж, ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэгдэх хөрөнгөөс бусад хөрөнгийн бодит үнэ дээр гүйлгээний зардлыг нэмсэн дүнгээр хэмжинэ.

Санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр эсвэл БҮЦӨБДО-р ангилахын тулд гэрээний мөнгөн гүйлгээ нь зөвхөн үндсэн төлбөрийн төлөлт болон үлдэгдэл төлбөрт ногдох хүүний төлөлтөөс бүрдсэн байх шаардлагатай. Энэ үнэлгээ нь 'зөвхөн үндсэн болон хүүний төлбөр' ("ЗҮХТ") шалгуур гэж нэрлэгддэг ба хэрэглүүр тус бүрд хийгдэнэ.

Компанийн санхүүгийн хөрөнгийг удирдах бизнесийн загвар нь мөнгөн урсгалыг бий болгохын тулд санхүүгийн хөрөнгийг хэрхэн удирдахыг тодорхойлох учиртай. Бизнесийн загвар нь гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах, санхүүгийн хөрөнгийг борлуулж ашиг, алдагдал хүлээн зөвшөөрөх, эсвэл хоёуланг нь хэрэгжүүлэх замаар мөнгөн урсгал үүсэх эсэхийг тодорхойлно. Хөрөнгийн зах зээл дээр зохицуулалт, дүрэм журмаар тогтоосон хугацаанд (хэвийн нөхцөлтэй арилжаа) санхүүгийн хөрөнгийг нийлүүлэхийг шаарддаг худалдан авалт буюу борлуулалтыг борлуулалтын өдөр хүлээн зөвшөөрнө. Борлуулалтын өдөр нь тухайн хөрөнгийг худалдан авах эсвэл худалдах үүрэг авсан өдрийг илэрхийлнэ.

Бизнесийн загварын үнэлгээ

Компани нь бизнесийнхээ загварыг тодорхойлохдоо өөрийн бизнесийн зорилгодоо хүрэхийн тулд санхүүгийн хөрөнгийг хэрхэн удирдаж буйг хамгийн зөв илэрхийлж чадах загварыг сонгох шаардлагатай. Компани бизнесийн загварыг хэрэглүүр тус бүрээр нь биш нэгтгэсэн багцын түвшинд үнэлэх бөгөөд дараах ажиглагдах хүчин зүйлсэд суурилдаг:

- Бизнесийн загвар ба тухайн бизнесийн загварт хамаарах санхүүгийн хөрөнгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэх ба байгууллагын тэргүүлэх удирдлагын бүрэлдэхүүнд тайлагнах
- Бизнесийн загварын ба тухайн бизнесийн загварт хамаарах санхүүгийн хөрөнгийн үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй эрсдэлүүд болон тухайн эрсдэлийг удирдан зохицуулах
- Бизнесийн удирдлагын албан тушаалтнуудад олгосон олговор (жишээлбэл, олговор нь удирдаж буй хөрөнгийн бодит үнэ цэнд эсвэл гэрээний мөнгөн гүйлгээ цуглуулсан хувь хэмжээнд суурилсан эсэх
- Үнэлгээний чухал асуудлуудад борлуулалтын хүлээгдэж буй давтамж, үнэ цэнэ, цаг хугацаа нь мөн орно.

Бизнесийн загварын үнэлгээ нь 'хамгийн муу хувилбар' буюу 'стресс хувилбар'-ыг үл харгалзан боломжит хувилбарууд дээр үндэслэнэ.

Хэрвээ анхлан хүлээн зөвшөөрөлтийн дараа мөнгөн гүйлгээ нь Компанийн анхны хүлээлтээс ялгаатай бол Компани нь тухайн бизнесийн загварт үлдсэн санхүүгийн хөрөнгийн ангиллыг өөрчлөхгүй бөгөөд ирээдүйд шинээр үүсэх эсвэл худалдан авах санхүүгийн хөрөнгийг үнэлэхэд тухайн мэдээллийг ашиглана.

ХИШИГ УУЛ ХК САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Компани хорогдуулсан өртгөөр хэмжигдсэн өмчийн хэрэгслээрх хөрөнгө оруулалтанд хүлээгдэж буй алдагдлыг хүлээн зөвшөөрөн бүртгэдэг. Тухайн санхүүгийн хэрэгслийг хүлээгдэж буй алдагдлын дүн анх хүлээн зөвшөөрч бүртгэснээс хойш эрсдэлийн өөрчлөлтийг үнэлж тайлант хугацаа болгонд шинэчилнэ. Компани дансны болон бусад авлагад нийт хугацааны туршид хүлээгдэж буй алдагдлыг тооцоолон бүртгэдэг.

Санхүүгийн хөрөнгийг данснаас хасах

Компани нь санхүүгийн хөрөнгийг дараах тохиолдолд данснаас хасна: санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусгавар болсон эсвэл санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгалыг хүлээн авах эрх ба хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүх эрсдэл болон өгөөжийг бусдад шилжүүлсэн. Хэрэв Компани нь санхүүгийн хөрөнгийг шилжүүлээгүй боловч санхүүгийн хөрөнгийг эзэмшихтэй холбоотой ихэнх эрсдэл ба өгөөжийг хадгалж үлдээгүй бол уг хөрөнгөөс компани -д үлдсэн хувь хэмжээгээр хөрөнгийг бүртгэлдээ хэвээр үлдээх ба төлбөр төлөх үүрэг байгаа бол холбогдох өрийг бүртгэнэ. Хэрэв компани нь шилжүүлсэн хөрөнгөтэй холбоотой эрсдэл ба өгөөжийн ихэнхийг өөртөө хадгалсаар байгаа бол санхүүгийн хөрөнгийг бүртгэлээс хасахгүй ба санхүүгийн хөрөнгөөр барьцаалсан зээлийн өрийг бүртгэнэ.

Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгийг данснаас хасахдаа тухайн хөрөнгийн дансны үнэ ба хүлээн авсан дүн болон авлагын нийлбэрийн зөрүүг ашиг алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хэрэгслийг цэвэр дүнгээр толилуулах нь

Компани нь хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь хааж, цэвэр дүнгээр тайлагнах эрхзүйн боломжтой үед санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр толилуулдаг.

Санхүүгийн өрийн ба өмчийн хэрэгсэл

Өр эсвэл өмчийн хэрэгслээр ангилах

Өрийн болон өмчийн хэрэгслийг тэдгээрийн гэрээгээр хүлээсэн нөхцлийн бодит байдал ба санхүүгийн өр төлбөр болон өмчийн хэрэгслийн тодорхойлолтонд үндэслэн өр эсвэл өмчийн хэрэгслээр ангилдаг.

Өмчийн хэрэгсэл

Компанийн бүх хөрөнгөөс өр төлбөрийг хассаны дараа үлдэх хэсгээс хувь хүртэх нөхцөл бүхий аливаа гэрээг өмчийн хэрэгсэл гэдэг. Компаниас гаргаж байгаа өмчийн хэрэгслийг хүлээн авсан мөнгөнөөс санхүүгийн хэрэгслийг гаргахтай холбоотой шууд зардлыг хассан дүнгээр хэмжиж бүртгэдэг.

Санхүүгийн өр төлбөр

Бүх санхүүгийн өр төлбөрийг анх бүртгэсний дараа үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр бүртгэдэг. Компанийн санхүүгийн өр төлбөр нь үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хэрэгслүүдээс бүрддэг.

ХИШИГ УУЛ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн өр төлбөр

Үр ашигт хүүгийн арга гэдэг нь санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртгийг тооцож, холбогдох хугацааны туршид хүүгийн зардлыг хуваарилах арга юм. Үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд төлөхөөр тооцоолсон бүх мөнгөн төлбөр (үр ашигт хүүгийн хувьд нөлөөлөх бүхий л төлбөр хураамж, ажил гүйлгээний зардал, хөнгөлөлт урамшууллыг багтаасан) -ийг санхүүгийн өр төлбөрийн хугацааны туршид эсвэл шаардлагатай тохиолдолд түүнээс богино хугацаанд хорогдуулахад хэрэглэдэг хүүгийн хувь юм.

Компани нь санхүүгийн өр төлбөрийг зөвхөн гэрээний үүрэг биелэгдсэн, цуцлагдсан эсвэл гэрээний хугацаа дууссан тохиолдолд данснаас хасна. Данснаас хасч буй санхүүгийн өр төлбөрийн дансны үнэ ба төлсөн дүн болон өглөгийн нийлбэрийн зөрүүг ашиг алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

(з) Нөөц ба болзошгүй өр төлбөр

Компани өнгөрсөн үйл явдлын үр дүнд хууль болон бусад үндэслэлээр өнөөгийн үүрэг хариуцлага хүлээж байгаа ба энэхүү үүргийг барагдуулахад эдийн засгийн өгөөж зарцуулах өндөр магадлалтай, мөн холбогдох тооцооллыг найдвартай хэмжих боломжтой үед төлөгдөх дүн болон хугацаа нь тодорхойгүй өр төлбөрийн нөөцийг хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ нь материаллаг тохиолдолд тухайн үүргийг төлөхөөр тооцоолсон зардлын өнөөгийн үнэ цэнээр нөөцийг бүртгэнэ. Эдийн засгийн өгөөжийг зарцуулах өндөр магадлалгүй эсвэл холбогдох дүнг найдвартай тооцоолох боломжгүй мөн эдийн засгийн өгөөжийг зарцуулах эсэхийг тодорхойлох боломжгүй болсноос бусад тохиолдолд, эдгээр үүрэг хариуцлагыг болзошгүй өр төлбөрөөр тодруулна. Нэг болон түүнээс дээш ирээдүйн үйл явдал тохиолдох, эсвэл эс тохиолдохоос хамаарч үүсэх эсэх нь тодорхой болох үүрэг хариуцлагыг, эдийн засгийн өгөөжийг зарцуулах эсэхийг тодорхойлох боломжгүй болсноос бусад тохиолдолд болзошгүй өр төлбөрөөр тодруулна.

(н) Холбоотой талын гүйлгээ

Компани болон Компанийн толгой компани болон түүнтэй холбоотой этгээдүүдийн хооронд нөөц, ажил үйлчилгээ эсвэл үүрэг хариуцлага шилжүүлэхдээ төлбөр нэхэмжилсэн эсэхээс үл хамааран тэдгээрийн хооронд хийгдсэн ажил гүйлгээг холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ гэнэ. Аливаа хувь хүн эсвэл түүний гэр бүлийн ойр дотны гишүүнийг дараах тохиолдолд Компанитай холбоотой гэж үзнэ:

- Компанийг шууд эсвэл хамтран хянадаг
- Компанийн үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг
- Компанийн болон Компанийн толгой компанийн удирдах ажилтан

Хэрэв дараах нөхцөлийн аль нэг нь хангагдаж байвал тухайн аж ахуйн нэгжийг Компанитай холбоотой гэж үзнэ:

- Тухайн аж ахуйн нэгж болон компани нь нэг бүлэг аж ахуйн нэгжийн бүрэлдэхүүнд багтаж байвал өөрөөр хэлбэл, толгой компани, охин компани болон нэг толгой компанид багтдаг охин компаниуд бүгд бусадтайгаа холбоотой гэсэн үг юм.
- Нэг аж ахуйн нэгж нь нөгөө аж ахуйн нэгжийн хараат эсвэл хамтарсан үйлдвэр бол эсвэл нөгөө аж ахуйн нэгжийг багтаасан бүлгийн нэг аж ахуйн нэгжийнх нь хараат эсвэл хамтарсан үйлдвэр бол
- Хоёр компани хоёулаа нэг гуравдагч этгээдийн хамтарсан хөрөнгө оруулалттай компани бол

ХИШИГ УУЛ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

- Нэг аж ахуйн нэгж нь гуравдагч аж ахуйн нэгжийн хамтарсан үйлдвэр ба харин нөгөө аж ахуйн нэгж нь уг гуравдагч аж ахуйн нэгжийн хараат компани бол
- Тухайн аж ахуйн нэгж нь дээр дурьдсан холбоотой талаар тодорхойлогдсон хувь хүний шууд эсвэл хамтарсан хяналтан дор байх
- Компанийг шууд эсвэл хамтран хянадаг этгээд нь тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд их хэмжээний нөлөөтэй байх, тухайн аж ахуйн нэгжийн, эсвэл түүний толгой компанийн удирдах ажилтан.

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ ҮНЭЛЭМЖ, ТООЦООЛОЛ, ТӨСӨӨЛЛҮҮД

Компанийн санхүүгийн тайлангуудыг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал тооцоолол, үнэлэмж хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлэмж нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, тусдаа санхүүгийн тайлангийн өдрөөр тайлагнагдсан хөрөнгө, өр төлбөрийн дүн, болзошгүй хөрөнгө, өр төлбөрийн тодруулга болон тайлант үед хүлээн зөвшөөрөгдсөн орлого, зардлын дүнд тус тус нөлөөлдөг. Ирээдүйд гарах бодит үр дүн нь эдгээр тооцооллоос зөрүүтэй байж болно.

Тооцоолол, түүнийг хийхэд хэрэглэсэн таамаглал, төсөөллийг байнга хянадаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийг өөрчлөлт хийгдсэн тайлант үе болон ирээдүйн тайлант үеүүдэд тус тус тусгадаг.

Үнэлэмж

Үйл ажиллагааны мөнгөн нэгжийг тодорхойлох

Компанид хамаарах, холбогдох нөхцөл байдлын эдийн засгийн агуулга дээр үндэслэн Компанийн үйл ажиллагааны мөнгөн нэгж нь Монгол Төгрөг байна гэж тодорхойлсон.

Компанийн үйл ажиллагаа явуулж байгаа эдийн засгийн үндсэн орчны мөнгөн нэгж нь Монгол төгрөг ба энэ нь Компанид хамаарах холбогдох гүйлгээ, үйл явдлууд, нөхцөлүүдэд голдуу нөлөө үзүүлдэг мөнгөн нэгж юм.

Санхүүгийн хэрэглүүрийн ангилал

Компанийн санхүүгийн хэрэглүүрүүд эсвэл түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг анхлан хүлээн зөвшөөрсөн гэрээний агуулга, санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөр, өөрийн хөрөнгийн хэрэглүүр гэж ангилдаг. Санхүүгийн хэрэглүүрийн хуулийн хэлбэрээс нь илүү агуулгыг харж тэдгээрийг санхүүгийн байдлын тайланд ангилж тайлагнадаг.

Үндсэн хөрөнгийн ашиглалтын жил

Компани хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө болон үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийг тусдаа санхүүгийн тайлангийн өдрөөр хянадаг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай бол залруулдаг. Тайлант жилийн эцэст үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийн тооцоололд өөрчлөлт гараагүй. Үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийг тооцоолоход үнэлэмж ашигладаг ба уг тооцоолол нь тайлант жилийн цэвэр ашигт нөлөө үзүүлэх боломжтой.

ХИШИГ УУЛ ХК
 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

7. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

	Барилга байгууламж	Машин тоног төхөөрөмж	Тээврийн хэрэгсэл	Тавилга эд хогшил	Компьютер, бусад хэрэгсэл	Бусад хөрөнгө	Нийт дүн
ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ӨРТӨГ							
Эхний үлдэгдэл	752,600,000.00	130,885,417.00	30,106,400.00	48,975,008.36	19,519,370.00	8,823,126.64	990,909,322.00
Нэмэлт		-					
Эцсийн үлдэгдэл	752,600,000.00	130,885,417.00	30,106,400.00	48,975,008.36	19,519,370.00	8,823,126.64	990,909,322.00
Хуримтлагдсан элэгдэл							
Эхний үлдэгдэл	209,712,662.00	101,283,557.53	30,106,400.00	48,109,641.68	18,193,370.00	6,492,860.16	413,898,491.37
Нэмэлт	18,815,000.00	8,330,439.53		747,469.68		132,564.16	28,025,473.37
Эцсийн үлдэгдэл	228,527,662.00	109,613,997.06	30,106,400.00	48,857,111.36	18,193,370.00	6,625,424.32	441,923,964.74
Дансны цэвэр дүн	524,072,338.00	21,271,419.94	-	117,897.00	1,326,000.00	2,197,702.32	548,985,357.26

ХИШИГ УУЛ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

8. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

	2023 MNT	2024 MNT
Биет бус хөрөнгө	400,000.00	400,000.00
	<u>400,000.00</u>	<u>400,000.00</u>

9. УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

	2023 MNT	2024 MNT
Урт хугацаат хөрөнгө оруулалт	459,625,625.25	459,625,625.25
	<u>459,625,625.25</u>	<u>459,625,625.25</u>

10. ДАНСНЫ ӨГЛӨГ

	2023 MNT	2024 MNT
Дансны өглөг	699,145,964.47	586,331,158.72
	<u>699,145,964.47</u>	<u>586,331,158.72</u>

11. ТАТВАРЫН ӨР

	2023 MNT	2024 MNT
ААНОАТ өр	314,272.55	29,210,850.29
НӨАТ өр	14,207,431.80	-
Бусад татварын өр	26,106,711.74	-
ХАОАТ-н өр	998,280.00	-
	<u>41,626,696.09</u>	<u>29,210,850.29</u>

13. НДШ-Н ӨГЛӨГ

	2024 MNT
НДШ-н өглөг	162,530.04
	<u>162,530.04</u>

12. УРТ ХУГАЦААТ ЗЭЭЛ

	2023 MNT	2024 MNT
Урт хугацаат зээл	32,097,388.91	32,097,388.91
	<u>32,097,388.91</u>	<u>32,097,388.91</u>

13. ЭЗДИЙН ӨМЧ

	2023 MNT	2024 MNT
Төрийн өмч	29,520,500.00	29,520,500.00
Хувийн өмч	57,304,500.00	57,304,500.00
	<u>86,825,000.00</u>	<u>86,825,000.00</u>

ХИШИГ УУЛ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

14. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

	2023 MNT	2024 MNT
Борлуулалтын орлого	1,545,302,613.07	1,504,363,621.54
	<u>1,545,302,613.07</u>	<u>1,504,363,621.54</u>

15. БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ

	2023 MNT	2024 MNT
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,247,854,497.23	1,019,867,209.61
	<u>1,247,854,497.23</u>	<u>1,019,867,209.61</u>

16. ХҮҮГИЙН ОРЛОГО

	2023 MNT
Хүүгийн орлого	26,250.32
	<u>26,250.32</u>

17. ЕРӨНХИЙ УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

	2023 MNT	2024 MNT
Цалингийн зардал	81,112,489.00	124,540,000.00
Нийгмийн даатгалын шимтгэл	9,283,464.19	11,900,900.00
Албан татвар хураамжийн зардал	8,968,503.50	-
Бичиг хэргийн зардал	6,210,745.47	-
Шуудан холбооны зардал	6,234,406.59	5,267,777.88
Мэргэжлийн үйлчилгээний зардал	22,776,700.00	-
Ашиглалтын зардал	84,551,898.25	81,733,633.86
Шатахууны зардал	14,101,364.56	10,047,121.86
Засвар үйлчилгээний зардал	14,872,121.79	126,793,090.91
Элэгдэл хорогдлын зардал	28,313,473.37	28,025,473.37
Бусад зардал	11,003,779.42	19,087,762.35
	<u>287,428,946.14</u>	<u>407,395,760.23</u>

18. БУСАД ЗАРДАЛ

	2023 MNT
Бусад зардал	46,015,807.55
	<u>46,015,807.55</u>

19. ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ

	2023 MNT	2024 MNT
Орлогын татварын зардал	1,001,916.97	7,710,065.17
	<u>1,001,916.97</u>	<u>7,710,065.17</u>

ХИШИГ УУЛ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

20. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЗОРИЛТ БОЛОН БОДЛОГУУД

Компанийн санхүүгийн эрсдэлийн удирдлагын бодлого нь Ажлын гүйцэтгэлд учирч болзошгүй сөрөг нөлөөг багасгахын тулд валютын, хүүгийн хувь, зээл ба төлбөрийн чадварын эрсдэлүүдийг удирдахын зэрэгцээ Компанийн хөгжлийг дэмжих санхүүгийн зохистой баялагтай байх явдлыг баталгаажуулахыг зорьдог.

а) Гадаад валютын эрсдэл

Компанийн гадаад валютын гүйлгээ нь ихэвчлэн төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба төгрөгөөс бусад валютаар хийсэн борлуулалт, худалдан авалтаас үүсэх валютын гүйлгээний томоохон хэмжээний эрсдэл байхгүй. Компани нь өөрийн гадаад валютаар илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг хамгийн сайн, боломжит ханшийг хэрэглэх ба орлого, зарлагыг нэг валютаар гүйцэтгэх замаар удирдах бодлогыг барьдаг.

Тайлант үеийн байдлаар тус компанийн гадаад валютаар илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгө, өр төлбөр нь эрсдэлгүй тул гадаад валютын эрсдэлийг үнэлэх мэдрэмжийн шинжилгээ хийдэггүй.

б) Төлбөрийн чадварын эрсдэл

Компани нь өөрийн бүх эргэн төлөлт болон санхүүжилтийн хэрэгцээ хангагдаж байгаа гэдгийг баталгаажуулахын тулд өөрийн үйл ажиллагааны мөнгөн урсгал ба санхүүжилтийг идэвхтэй хянаж байдаг. Компани нь өөрийн төлбөрийн чадварын зохистой байдлын ерөнхий удирдлагын нэг хэсэг болгон, өөрийн ажлын капиталын шаардлагуудыг хангахад хүрэлцэхүйц хэмжээний бэлэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг бэлэн байлгадаг.

Компанийн харилцагчид зээлийн нөхцлөөр худалдан авалт хийгээд түүнийгээ төлж чадахгүй болсноор Компанид зээлийн эрсдлийг үүсгэдэг. Компанийн удирдлага нь өндөр зээлийн зэрэглэлтэй дотоодын банк болон санхүүгийн байгууллагуудад байршуулсан банкны харилцах дансанд харгалзах санхүүгийн зээлийн эрсдлийн түвшинг бага гэж үзсэн. Компанийн удирдлага нь дефолтын магадлал нь бага гэж үзсэн тул нөөц санг байгуулаагүй.

Компанийн удирдлага дансны болон бусад авлагын эргэн төлөгдөх магадлалыг үнэлэхийн тулд авлага цуглуулалтын түүхэн мэдээлэл болон ирээдүйг таамаглаж буй мэдээллийг харгалзан тус бүрийн үнэлгээ хийдэг. Компани нь тооцоолол, зээлийн түүхэн мэдээлэл, зээлдэгчийн хугацаа хэтрэлттэй авлагын статусыг одоогийн болон ирээдүйн эдийн засгийн чиг хандлагыг харгалзан тохируулах байдлаар хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцоолдог. Иймд эдгээр хөрөнгийн зээлийн эрсдлийн багц нь уг авлагын хугацаа хэтэрсэн статусаар тодорхойлсон тусгайлсан үнэлгээнд үндэслэн толилуулагддаг.

21. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮРҮҮДИЙН БОДИТ ҮНЭ ЦЭНЭ

Санхүүгийн хэрэглүүрүүдийн ангилал нэг бүрийн бодит үнэ цэнийг ойролцоолон тооцоход (эдгээр үнэ цэнийг тооцох нь практик дээр боломжтой бол) дараах арга төсөөллүүдийг ашигладаг.

ХИШИГ УУЛ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь богино хугацаат санхүүгийн хэрэглүүр учраас тэдгээрийн бүртгэлийн дүн нь бодит үнэ цэнэтэйгээ ойролцоо байдаг.

Авлага болон бусад өглөг

Худалдааны зээлийн ердийн нөхцөлд хамрагдах авлага, бусад арилжааны болон бусад өглөгийн дансны үнэ, дансны харьцангуй богино хугацааны шинж чанараас хамааран бодит үнэ цэнтэй ойролцоо утгатай байна.

Холбоотой талуудад өгөх өглөг

Холбоотой талуудад өгөх өглөгүүд нь хугацаагүй буюу хүссэн үед нь төлөх нөхцөлтэй учраас тэдгээрийн бүртгэлийн дүн нь бодит үнэ цэнэтэйгээ ойролцоо байдаг.

22. КАПИТАЛЫН УДИРДЛАГА

Компанийн хөрөнгийн удирдлагын үндсэн зорилго нь өөрийн бизнесийг дэмжих, хувь нийлүүлэгчийн үнэ цэнийг нэмэгдүүлэх явдал юм.

23. ТАЙЛАНГИЙН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

Санхүүгийн тайланд нөлөөлөхүйц, тодруулахыг шаарддаг үйл явдал гараагүй.